



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 18,000,000.00 (арван найман сая) төгрөгийн балансын үнэ, 14,500,000.00 (арван дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Дорноговь аймгийн Хатанбулаг сум дахь Хилийн цэргийн 0168 дугаар ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001737

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн  
13.11 дугаар тогтоолын хавсралт



Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын балансаас  
Дорноговь аймгийн Хатанбулаг сум дахь Хилийн цэргийн 0168 дугаар ангийн балансад шилжүүлэх хөрөнгө

Д/д	Автомашинны төрөл, зориулалт, улсын дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	"Asia SH33S", галын, 74-59 ДГО	2013	57555	18,000,000.00	14,500,000.00	3,500,000.00
				18,000,000.00 (арван найман сая)	14,500,000.00 (арван дөрвөн сая таван зуун мянган)	3,500,000.00 (гурван сая таван зуун мянган)

НИЙТ ДҮН: